



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот


Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын 2.а, 2.б хэсэг, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2023 он/-г хавсралтаар баталсугай.

2. 2020 онд батлагдсан төсвийн хүрээнд “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2023 он/-ний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тайлагнаж ажиллахыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гүнболд/-т, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /Ц.Ганхүү/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах төсвийг жил бүр улсын төсөвт тусгуулах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.



Х.БАДЕЛХАН

151010044

Барилга, хот байгуулалтын сайдын
2020 оны 01 дугаар сарын 07 өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

**“ГУДАМЖ, ЗАМ, ТАЛБАЙ, ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙГ ХАЯГЖУУЛАХ ЖУРАМ”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ /2020-2023/**

Журамд тусгагдсан үйл ажиллагаа болон журам шинэчлэн батлагдсантай холбоотой үйл ажиллагаа	№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин 2019	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага
1. Хаягийн зураг зохиох, баталгаажуулах	1.1.	Нийслэл, 21 аймаг 330 сум, 25 жижиг суурингийн хэмжээнд 2013-2016 онд хийгдсэн хаягийн зургийг засварлаж мэдээллийн сан үүсгэх	2019	Улсын төсөв	0.0	80% 2013-2016 оны хооронд хийж гүйцэтгэсэн	80%	ГЗБГЗЗГ
			2020				100%	ГЗБГЗЗГ
	1.2.	Нийслэл, 21 аймаг 330 сум, 25 жижиг суурингийн хэмжээнд хийгдсэн хаягийн зургийн нөхөн бүрдүүлэлт хийх, 1:100 000-ны масштабтай хаягийн зурагт зураглах боломжгүй шинээр үүссэн суурьшлыг зураглах	2019	Улсын төсөв	150.0	5%	5%	БХБЯ ¹ , ГЗБГЗЗГ ²
			2020				50%	БХБЯ, ГЗБГЗЗГ
			2021				100%	БХБЯ, ГЗБГЗЗГ
	1.3.	Тусгай хамгаалалттай газарт (Горхи Тэрэлж, Нүхт, Жаргалантын ам гэх мэт) хүн ам олноор бий болсон амралт аялал жуулчлалын газруудын объектуудын 1:1000-ны	2020	Улсын төсөв	350.0	0%	30%	БХБЯ, ГЗБГЗЗГ
			2021				60%	БХБЯ, ГЗБГЗЗГ
			2022				100%	БХБЯ, ГЗБГЗЗГ

¹ Барилга, хот байгуулалтын яам

² Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар

		масштабтай байр зүйн зураг хийж, хаягийн зураг зохиох.						
2. Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг эрхлэх, нийтэд хүргэх	2.1.	Хаягийн мэдээллийн системийг үүсгэж газрын кадастрын мэдээллийн сантай холбох	2019	Улсын төсөв	350.0	30%	30%	ГЗБГЗЗГ
			2020				100%	ГЗБГЗЗГ
	2.2.	Хаягийн мэдээллийн санг үүсгэгч байгууллагын мэдээллийн санг түгээгч байгууллагуудын мэдээллийн сантай холбох	2020		230.0	0%	20%	БХБЯ, ГЗБГЗЗГ, НЗДТГ ³
			2021				70%	БХБЯ, ГЗБГЗЗГ, НЗДТГ
			2022				100%	БХБЯ, ГЗБГЗЗГ, НЗДТГ
	2.3.	Хаягийн мэдээллийн нэгдсэн санд суурилсан газар зүйн мэдээллийн болон зам заагч системийг хөгжүүлэх	2020		100.0	0%	10%	БХБЯ, ГЗБГЗЗГ
			2021				50%	БХБЯ, ГЗБГЗЗГ
			2022			100%	БХБЯ, ГЗБГЗЗГ	
3. Нийгмийн үйлчилгээнд ашиглагдаж буй хаягтай холбогдсон иргэн, хуулийн этгээдийн баримт бичигт өөрчлөлт оруулах	3.1.	Газар эзэмшигч, ашиглагчийн гэрчилгээ солих	2020	Улсын төсөв	457.4	20% /2018 оны Газрын нэгдмэл сангийн ангиллын тайлангаар 476,419 байна /	25%	БХБЯ, ГЗБГЗЗГ
			2021				35%	БХБЯ, ГЗБГЗЗГ
			2022				80%	БХБЯ, ГЗБГЗЗГ
			2023				100%	БХБЯ, ГЗБГЗЗГ
	3.2.	Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, газар өмчлөгчийн гэрчилгээ солих.	2020		8216.0	2% /2019 оны байдлаар нийт 1.1 сая орчим байна /	5%	УБЕГ ⁴
			2021				20%	УБЕГ
			2022				60%	УБЕГ
			2023				100%	УБЕГ
	3.3.	Монгол Улсын иргэний цахим үнэмлэхний хаяг солих	2021		41129.0	0.1% /2019 оны байдлаар 2,210,003	10%	УБЕГ
			2022				50%	УБЕГ

³ Нийслэлийн засаг даргын тамгын газар

⁴ Улсын бүртгэлийн ерөнхий газар

			2023			цахим үнэмлэх байна /	100%	УБЕГ
	3.4.	Хуулийн этгээдийн гэрчилгээг солих.	2021		2363.1	0% /2019 оны байдлаар 207752 байна /	20%	УБЕГ
			2022				60%	УБЕГ
			2023				100%	УБЕГ
4. Хаягийн тэмдэглэгээг үйлдвэрлэх, байрлуулах		Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээ солих.	2021		21700.0	172 сум хаягийн тэмдэг байршуулса н	58 сум	БХБЯ, ГЗБГЗЗГ, НЗДТГ
	4.1.		2022	Улсын төсөв			100 сум, Нийслэл	БХБЯ, ГЗБГЗЗГ, НЗДТГ
			2023				Нийслэл	БХБЯ, ГЗБГЗЗГ, НЗДТГ
Бүгд дүн					75046.4			

----- о О о -----